

Ой тогтоолтын дэлхийн аварга 2019 – Тэмцээний мэдээлэл!

Сайн байцгаана уу!

Үүнийг уншиж байгаа бүх ой тогтоолтын тамирчиддаа энэ өдрийн мэндийг хүргэе!

IAM – ээс зохиож буй 3 дахь удаагийн Ой Тогтоолтын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн маань 11 сарын 29 – оос 12 сарын 1 хооронд Хятад улсын үзэгслэнт Зухай хотод зохиогдох гэж байна.

1. Тэмцээний цээжлэх материалын сонголт

Бид энэ жил тэмцээний 10 төрөлөөс 9 – ийг нь дижитал хэлбэрээр хийх сонголтыг тамирчиддаа олгож байна(Хурдны хөзөр төрөлийг заавал жихэнэ хөзрөөр хийнэ). Дараах холбоосоор та бүхэн дижитал бэлтгэл хийж болно:

iamwmc.com/competition/training.html

Бид яг ийм аргаар German Open болон French Open тэмцээнүүдээ амжилттай зохиосон байгаа.

Тамирчид уламжлалт цаасан хэлбэр эсвэл шинэ дижитал хэлбэрүүдээ өөрсдөө сонгох болно.

2. Тэмцээний шагналын сан

Энэ жилийн нийт шагналын сан:

500,000 Юан

Энэ дүн нь ойролцоогоор 63,000 Евро эсвэл 70,000 доллар

3. Тэмцээний цагийн хувиар

Бид яг тодорхой цагийн хувиарыг 11 сарын 1 – ээс өмнө гаргах болно. Тэмцээн маань өмнөх жилүүдийнхээ тэмцээнүүдтэй төстэй цагийн хувиараар явагдах болно. Jiudian 2 төрөл маань эхний болон хоёр дахь өдрийн төгсгөлд явагдах болно.

4. Тэмцээний хаяг

Зухай Теливизийн цамхаг, 4 давхарт

500 Yinhua Rd

Xiangzhou district

Zhuhai City

Google Maps линк: <https://goo.gl/maps/ksagokL96nAHgoQE7>

5. Асуулт хариултын WECHAT груп

Хэрвээ таньд ямар нэгэн асуулт байвал дараах Wechat групп ороод асууж болно.



6. Мастер цол

Энэ жилийн тэмцээн маань мастер цолуудаа олгох болно.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг 11 сарын 15 – аас өмнө нийтлэх болно. Санал хүсэлт байвал дараах хаяг руу явуулаарай.

info@iam-memory.org

7. Тэмцээний төрөлүүд: Яг л стандарт дэлхийн аваргын төрөлүүд гэхдээ сонгож болох 2 нэмэлт төрөлтэй

7.1 Эхлэл

Та бүхэн гарчиг уншаад л ойлгож байгаа биздээ. Зүгээр энгийн дэлхийн аваргын төрөлүүд гэхдээ та өөрөө хүсвэл 2 нэмэлт төрөл байгаа. **Энэ төрөлүүдэд орохгүй байлаа гээд таны үзүүлэлтэд огт нөлөөлөхгүй. Харин орох юм бол зарим нэмэлт боломжууд байгаа.**

7.2 Төрөлүүд

Та бүхэний мэдэхээр дэлхийн аваргын тэмцээн 10 төрлийн дагуу явагддаг. Харин энэ Jiuduan тэмцээн маань 6 төрлөөр явагддаг. Энэ 6 - аас 4 нь манай дэлхийн аваргын тэмцээнтэй адилхан учраас та үлдсэн хоёр төрөлийг нь хийгээд л нэг сумаар хоёр тэмцээнд зэрэг орох боломжтой. Jiuduan 2 нэмэлт төрөл маань:

1. **Үсэг цээжлэх:** Англи хэлний 26 үсэгнээс санаандгүйгээр сонгогдсон 36 үсэгийг яг хурдны хөзөр төрөлтэй адилхан маягаар цээжлэнэ. Тэмцээний эхний өдрийн хамгийн сүүлд явагдах болно.
2. **Сонгодог шүлэг:** Тэмцээний хоёр дохь өдрийн хамгийн сүүлд явагдах болно.

Та энэ 2 төрөлд орох шаардлагагүй харин хүсвэл л орж болно.

7.3 Яагаад 2 нэмэлт төрөлд орвол зүгээр вэ?

1. Энэ хоёр төрөл маань богинохон
2. Энэ хоёр төрөл маань амархан бас хөгжилтэй
3. Энэ хоёр төрөлд оролцсоноороо та илүү их мөнгө хожих боломжтой
4. Та дэлхийн аваргын тэмцээний бүртгэлийн хураамжаа төлсөн

7.4 Сонгодог шүлэг төрөл

Энэ төрөлийн маань онцлог тал нь та тэмцээнээсээ өмнө цээжлжх материалаа аваад хүссэн хугацаагаараа цээжилж болно. Харин тэмцээн дээр таны цээжилсэн шүлэгнүүдээс зарим үг/өгүүлбарүүдийг арилгасан санах хуудсыг таньд өгөх болно.

Энэ шүлэгнүүдийг та лараах холбоосоор татаж болно:

<http://www.iam-memory.org/downloads/>

Англи болон Хятад гэсэн хоёр хэлний сонголтууд байгаа.

Энэ төрөл 9 өөр шаттай. Их шүлэг цээжилж санах тутам шат ахина гэж ойлгож болно.

Дараах холбоосоос нэмэлт мэдээлэл авч болно:

www.jiyijiudian.cn

8. Шагналын сангийн мэдээлэл

Дээр дурдсанаар нийт шагналын сан маань 500,000 юуань

1. **125,000 юуань** нь зөвхөн дэлхийн аваргын арван төрөлдөө оролцсон тамирчидад олгогдоно.
2. **125,000 юуань** нь дэлхийн аваргын арван төрөл болон Jiudian – ий зургаан төрөлд оролцсон тамирчидада олгогдох болно. Хэрвээ та энэ хоёр тэмцээний давхацсан 4 төрөлд шилдэг гуравын нэг болвол та зөвхөн тэр төрөлөөсөө давхар шагнал авах боломжтой. Нэг сумаар хоёр туулай буудах том боломж шүү!
3. **250,000 юуань** нь Jiudian тэмцээний Дан буюу зэрэг авсан тамирчидад олгогдоно. Jiudian тэмцээн нь 9 дантай ба дан болгон нь ямар нэгэн болзолыг хангаж авах болно. Энэ 9 дангийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосноос авна уу:
www.jiyijiudian.cn/newsinfo/419522.html

А. Энэд анхаарах нэг зүйл нь таны хэддүгээр дан авах нь таны бүх 6 Jiudian төрөлийн үзүүлэлтээс шалтгаална. Энэ нь хэрвээ та 5 төрөд дээр 8-р дангийн болзол хангасан ч үлдсэн нэг төрөл дээр нь 2-р дангийн хэмжээнд байвал та 2-р дан авна гэсэн үг.

Б. Сонгодог шүлэг төрөл дээр маш сайн анхаарах нэг зүйл нь та өндөр дан авахын тулд заавал бүх доор байгаа дангуудын болзолыг хангасан байх ёстой.

В. Бидний зүгээс энэ хатуу дангийн зэрэглэлийг Jiudian зохион байгуулагчидаас арай зөөлрүүлж өгөхийг хүсэх болно. Магадгүй хамгийн муу дан авсан нэг төрөлийг нь үл тооцох систем байж болох уу гэж асууна.

9. Бүртгэл

Та дараах холбоосоор орж бүртгэлээ хийлгэх боломжтой:

<http://www.iam-memory.org/iam-wmc-2019-registration/>

Анхаарал хандуулан уншсанд баярлалаа!

IAM – ийн хамт олон